

ЗАВХАН АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2025-07-24

Улиастай

1. АЖИЛТУУДЫН ҮР БҮТЭЭЛТЭЙ АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙДАЛ:

❖ Аймгийн Засаг даргын 2025 оны А16 дугаар захирамжаар шийдвэрлэгдсэн 20 сая төгрөгнөөс байгууллагын архивын өрөөний тохижилтод Миракл Полар Рэй ХХК-аас 6 ширхэг нягтруулах шүүгээ 8,4 сая төгрөгөөр худалдан авч суурилуулан архивын хадаглалт хамгаалалтыг сайжруулсан.



❖ Арина Компьютерс ХХК-аас усны аппарат, хөргөгч, тоос сорогч, печь, Говь хангай мебель ХХК-аас гал тогооны тавилга, Некст электроникс ХХК-аас шарах шүүгээ, будаа агшаагч гэх мэт гал тогооны бусад эд зүйл худалдан авч үдийн цайны өрөөний тохижуулсанаар албан хаагчдын ажиллах нөхцөл, эрүүл ахуйн байдал сайжирсан.



❖ Алтан-Наруул ХХК-аас 1 ширээ 2, сандал 4 ширхэг, ээлжийн албан хаагчдад шүүгээ 1 ширхэг, БСБ Коммерс ХХК-аас олон үйлдэлт өнгөт принтер 1 ширхэгийг худалдан авч албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулсанаар албан хаагчдын ажлын бүтээмж цаг ашиглалт сайжирсан.



❖ Мөн 2026 онд байгууллагын конторын барилга шинээр барих саналыг аймгийн Засаг дарга дэмжин 2 давхар барилгын зураг төсвийг 92,7 сая төгрөгөөр хийлгэсэн.

❖ Шинээр баригдах конторын төсөв 4.5 тэрбум төгрөгийн 2026 оны улсын төсөвт суулгуулахаар санал хүргүүлэн ажиллаа. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Баянтэс сумдын Цаг уурын өртөөний барилга баригдахаар төлөвлөгдсөн тул барилгын зургийн компанид холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлэн ажиллаж байна.

❖ Монгол улс, БНСУ-ын Байгаль орчны яамдын хамтын ажиллагааны хүрээнд буцалтгүй тусламжаар 21 аймгийн Цаг уур, орчны шинжилгээний төвүүдийг агаарын чанарын автомат станцтай болгох ажлын хүрээнд Завхан аймгийн төв Улиастай сумд агаарын чанарын автомат станц 05 сарын 16-20-ны өдрийн хооронд бүрэн суурилуулагдаж ашиглалтад орж эхлэв.



Багаж угсралт болон сургалтын үйл явц



Автомат станцын нээлтийн үйл ажиллагаа

❖ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Everest Cross 200ccZS200GY-3 маркын мотоцикль 5 ширхгийг авч Гадаргын ус судлалын харуулын албан хаагчдад хүлээлгэн өгсөн.



❖ Аймгийн Засаг даргын тамгын газрын ОНХС 15 сая төгрөгний хөрөнгийг тусгуулан Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зарцуулсан.

❖ Аймгийн Засаг даргын Шувуун харуул ХХК-тай байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Говийн сумдад цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэх үзүүлэхэд 20 сая төгрөгийг тусгуулсан.

❖ Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газраас Автомат станцад зайлшгүй шаардлагатай газардуулгын материалын зардал 2,7 сая төгрөгийг шийдвэрлэж өгсний дагуу худалдан авалтыг хийж газардуулгыг стандартын дагуу хийж гүйцэтгэв. Хамтран ажилласан сумын удирдлагуудад талархал илэрхийсэн болно.



2.ХАМТ ОЛНЫ ТӨЛӨВШИЛ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, АЖИЛТНЫ НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ.

❖ Нийт ажилчдын хурлаар байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээ томилон үйл ажиллагааны болон сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Хороо байгуулагдсанаас хойш хамт олны дунд танилцуулга, бусад мэдээ мэдээлэл, хууль тогтоомж, дүрэм журмыг байгууллагын вэйб сайтад байршуулж, ёс зүйтэй төрийн албан хаагч байх соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг авч ажиллаж байна.



2025 оны эхний хагас жилд ёс зүйн дэд хорооноос танхимаар-1, онлайнаар-1 сургалт зохион байгуулсан.



Ёс зүйн дэд хороо эхний хагас жилийн байдлаар төлөвлөсөн ажлаа бүрэн гүйцэтгэж, хагас жилийн тайлангаа ХНУТМ системд сар, улирал, хагас жилээр хугацаандаа тайлагнасан. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн баталгааг хангаж эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлээр сайн ажилласан зарим гишүүдэд урамшуулалыг тооцож олгуулсан.

Авлигын тухай цахим сургалтад байгууллагаараа хамрагдсан. Мөн ЦУОШГ-аас хүргүүлсэн видео, зураг контентийг байгууллагын албан хаагчдын групп хуудсаар 4 удаа нийтэлсэн байна. Төв болон орон нутгийн албан хаагчид үйл ажиллагаанд нэгдэж, нийтэллийг хуваалцаж идвэхтэй ажиллалаа.



Авлига, архи, тамхины эсрэг сурталчилгаа, сургалт, мэдээлэх хуудасууд байршуулан нөлөөллийн арга хэмжээ авч ажилласанаар хамт олны дунд архи, тамхины хэрэглээ байхгүй, ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна.

❖ Аймгийн Жендерийн салбар хорооноос ирүүлсэн зөвлөмж, уриалга, аянд нэгдэж албан хаагчдад сурталчилан ажиллаж жендерийн асуудалгүй хамт олон болсон.

❖ Ахмад настны тухай хуулийн 11.1.1. Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлэх арга зүйгээр хангах ажлын хүрээнд: Судалгааны инженерт хариуцуулан энэ онд тэтгэвэрт гарах 5-н хүнтэй групп чат нээж мэдээлэл өгсөн мөн утсаар зөвлөгөө өгөх мөн сургалтанд ирсэн 3-н хүнтэй уулзсан.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа

❖ Ус цаг уур, орчны шинжилгээний ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн журам, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журмыг инженер, техникийн 37 ажилтан нийт 98 албан хаагч нарт танилцуулан зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Мөн Байгаль орчны шинжилгээний лабораторийн инженер, техникч, “Завхан Бороо-1” экспедицийн бие бүрэлдэхүүнд бусад ажилтан нарт хөдөө орон нутагт ажиллах үед замын хөдөлгөөний болон бусад аюулгүй ажиллагааны зааварчлагаа өгч батлаггаажуулалт хийлгэн ажиллаа.

-Тосонцэнгэл сумын Ус судлалын харуулд 330,0 төгрөгний тросс, автомат станцад 1,7 сая төгрөгний хэрэгсэл авч өгсөн.

-Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллаж байгаа Байгаль орчны лабораторийн 4-н албан хаагчид хагас жилийн байдлаар хор саармагжуулах 3,3 сая төгрөгний санхүүжилт зарцуулан хор саармагжуулалт хийсэн байна.

-БОШЛ- албан хаагч нарт хөдөлмөр хамгааллын нэг удаагийн хувцас, аптекний иж бүрэн хангалт, резинэн бээлий, маск, 00 цаас гарын шингэн саван, сав суулгах

угаах шингэн, зай, усны харуулын ажиглагч нарт зай зэрэг 2,2 сая хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангаж ажилласан байна.

-7 өртөө болон аймгийн төвийн байрны галын аюулгүй байдлыг хангах зорилгоор 25 ширхэг галын хорыг 1,1 сая төгрөгөөр авсан.



-Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг ханган 2024 оны 12 дугаар сард Ахмадын санг үүсгэн байгуулж 40 сая төгрөг төвлөрүүлсэн. Үүнээс Ахмадын сангийн журмын дагуу сар шинийн баяраар төв болон орон нутагт амьдардаг байгууллага харьяалалтай нийт 35 ахмадад нэг хүнд 100 мянга, нийт 3,5 сая төгрөг өгсөн.

-Сар шинээр аймгийн төвд амьдарч байгаа ахмадуудыг хүлээн авах тавгийн идээ, цайнд 500 мянган төгрөг зарцуулсан.

-Эх үрсийн баяраар 6 сарын 1-д Алдарт эхийн одонтой эхчүүдэд хүндэтгэл үзүүлж 19 хүнд тус бүр 100.000 төгрөг өгсөн.



Шагнал: Цаг уурын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан хөдөлмөр зүтгэлийг нь үнэлж Төрийн одонд 7 тодорхойлсон. Дэлхийн цаг уурчдын өдрөөр Байгаль орчин аялал жуулчлалын яамны тэргүүний ажилтнаар 4, Жуух бичгээр 2, Цаг уур орчны шинжилгээний газрын Жуух бичгээр 5 албан хаагч шагнагдсан.



Ардын хувьсгалын 104 жилийн ойн байр наадмыг тохиолдуулан Төрийн дээд одон Алтан гадсаар 2 хүн, Хөдөлмөрийн хүндэт медалиар 2 хүн, Байгаль орчин

уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тэргүүний ажилтан цол тэмдэгээр 4 хүн, Хүндэт жуухаар 2 хүн шагнагдсан байна.



3.БАЙГУУЛЛАГАД ГАРСАН АЖЛЫН АХИЦ, АМЖИЛТ:

◆ Ус цаг уур орчны шинжилгээний төв нь “ШИНЭЧЛЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ” аяны хүрээнд “МЭРГЭЖИЛ СУРТАЛЧИЛАХ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ 2025 оны 06 сарын 05-нд аймгийн Нутгийн ордны өмнөх төв талбайд 12 цагаас 16 цаг хүртэл зохион байгууллаа.

Уг өдөрлөгөөр Цаг уурын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил бүхнээр сурталчилж, цаг уурын бүх төрлийн мэдээллийг ард иргэдэд тараалаа. Мөн МУИС, Дархан ХААИС-ын Цаг уур, ус судлалын тэнхимийн бакалаврын хөтөлбөрийг 12 дугаар анги төгсөж буй сурагчдад сурталчилан таниуллаа. 12 дугаар анги төгсөж буй сурагчдын байгууллага дээр урьж байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь сурталчилж байгууллагаа танилцуулсан.

Өдөрлөгт ирсэн ард иргэдээс цаг уурын байгууллага, мэдээ мэдээллийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг нийт 76 хүнээс 5 асуултаар санал авахад 69 хүн буюу 90.98 хувь САЙН гэж дүгнэгдсэн нь манай байгууллагын ажлын ахиц амжилтыг харуулж байна.





06-сарын 05-нд орон нутгийн бүх өртөө, харуул өөрсдийн ажиглалтын талбай, ажлын байранд төгсөх ангийн сурагчдыг урьж ажлаа танилцуулж, МУИС, Дархан ХААИС-ын Цаг уур, ус судлалын тэнхимийн бакалаврын хөтөлбөрийг танилцуулан ажилласан.



Тосонцэнгэл сумын цаг уурын Өртөөнд 06 сарын 06-нд байгууллагаараа очиж “МЭРГЭЖИЛ СУРТАЛЧИЛАХ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ зохион байгууллаа.

